

“ТАВИЛГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

2026 оны 04 сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдсан газар огноо: Тавилга ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 11.00 цагт Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Гандан Энхтайвны өргөн чөлөө, 35/2, Шуудангийн гудамж, Ramada/рамада/ зочид буудлын 4 дүгээр давхрын Кристал танхимд эхэллээ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлын дарга Ц.Байгалмаа нээв.

Хурлын дарга Ц.Байгалмаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тооллогын комиссын дарга хурлын ирцийг танилцуулъя.

Тооллогын комиссын дарга Л.Цэрэндолгор: Сайн байцгаана уу? “Тавилга” ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дарга Л.Цэрэндолгор байна. Тооллогын комиссын ирцийн дүнг танилцуулъя.

1. “Тавилга” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 6 хувьцаа эзэмшигч оролцож нийт саналын эрх бүхий хувьцааны 62,76%-д хүрснийг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т заагдсаны дагуу хувьцааны 62,76%-ийн хувьцаа эзэмшигчид оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцугай.

Хурлын дарга Ц.Байгалмаа: /цаашид “Хурлын дарга” гэх/ үг хэлэв: Тооллогын комиссын даргад баярлалаа. Одоо хурлынхаа үйл ажиллагааг эхлүүлье.

Манай компанийн томоохон хувьцаа эзэмшигч болох Батхүү гуай хуралдаа ирээгүй байна. Нарийн бичгийн дарга яриад ирж байна уу? гэж лавлаарай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын /цаашид “ХЭХ” гэх/ зарыг журмын дагуу хүргэж ажилласан талаар хурал зохион байгуулах комисс хувьцаа эзэмшигчдэд тайлбар хийгээрэй.

Нарийн бичгийн дарга: Сайн байцгаана уу? “Тавилга” ХК-ийн 2025 онд Нарийн бичгийн даргаар ажилласан Х.Байржаргал байна. ХЭХ-ын зарыг СЗХ-ны Хурлын зар хүргэх журмын дагуу хүргэсэн. UBS телевизээр 2 удаа зарлуулж, Өдрийн сонинд 2 удаа хурлыг зарыг олон нийтэд түгээсэн. Мөн Хөрөнгийн биржийн сайтад хурлын зарын мэдэгдлийг нийтэлсэн байгаа. Мөн журмын дагуу Брокер, дилерийн байгууллагуудад ХЭ хурлын танилцуулга материалыг хүргэж, үйлдвэрийн байран дээр хурлын материалыг байршуулж, бүртгэлийн өдрөөр Үнэт цаас хадгаламжийн төвөөс тархалтын мэдээг гаргуулж ажилласан.

Хурлын дарга: За тэгвэл, одоо 11:25 минут болж байна. Хувьцаа эзэмшигчдийн ирц 62,76%-д хүрч ирц бүрдсэн байх тул Тавилга ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хөтөлбөрийн дагуу эхлүүлье. Өнөөдрийн ээлжит хурлаар дараах гурван асуудлыг хэлэлцэж батална.

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
3. Ногдол ашиг хуваарилах, эсэх тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг танилцуулж батлах

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр ХЭ-ээс асуух асуулт, санал байгаа бол хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч Ч.Баясгалант: Байхгүй. Дээрх гурван асуудлыг хэлэлцэж батлахыг дэмжиж байна.

Хурлын дарга: Хуралд оролцогчдоос санал гарсангүй. Байхгүй бол ингээд хэлэлцэх асуудлаа батлах уу? (хуралд оролцогчид бүгд зөвшөөрөн)

Хурлын дарга: Хэлэлцэх асуудлуудыг баталсан тул өнөөдрийн хурлаар хэлэлцэх 3 асуудлын тухай товч танилцуулгыг гүйцэтгэх захирал миний бие та бүхэнд танилцуулъя.

Та бүхний өмнө танилцуулга материалууд хүргэгдсэн байгаа тул хараад яваарай. (2025 оны үйл ажиллагааны дүгнэлт болон ТУЗ-д нэр дэвшигчдийн тухай танилцуулгыг 30 минут орчим хийн)

Танилцуулгатай холбоотойгоор та бүхнээс асууж тодруулах зүйлийг хүлээн авч хариулъя.

Хувьцаа эзэмшигч Ч.Баясгалант: 2025 оны танилцуулга тайлангай танилцлаа. Татварын өр ширээ багасгаад төлөөд явж байгаа нь сайшаалтай байна. Үйлдвэрийн байранд энэ жил ихээхэн оорчлолт, засвар үйлчилгээ хийсэн харагдаж байгаа нь сайшаалтай байна.

Хурлын дарга: Манай компанийн үйлдвэрийн байр 50 гаруй жил болж байгаа хуучин барилга учраас муудсан хэсэгт засвар үйлчилгээг бага багаар хийхгүй бол түрээслэгчид олдохгүй, хүндрэлтэй болоод байгааг та бүхэн ойлгоорой.

Хувьцаа эзэмшигч Ц.Баярмаа: Өмнө нь орох, гарах хэсэг бороо, цас орсон үед их шалбааг үүсэж, ус тогтож мөн хавар зуны улиралд их шороо тоос босдог байсан. Үйлдвэрийн гадаа хийгдсэн зам хучилтын ажил их зөв шийдэл болсон байна гэж харагдаж байна.

Хурлын дарга: Үйлдвэрийн гадна зам тавигдаж байгаагай холбогдуулан манай гадна замын үүдний хэсгийн орох гарах хэсгийн замын хучилтын ажлыг замын компанитай гэрээлэн хийж гүйцэтгэсэн. Ингэснээр үүдний хэсгээс авхуулан тоос шороо бужигнах нь багасаж, харагдах байдлаар ч тэр ихээхэн цэгцтэй болж өгсөн.

Хувьцаа эзэмшигч Ц.Банзрагч: Үйлдвэрийн гадна яагаад автомат хаалт суулгасан бэ?

Хурлын дарга: Мөн Үйлдвэрийн гадна том хаалга байнга онгорхой байх нь дараах аюулыг дагуулна гэж үзсэн. Үүнэ:

- Гаднаас хүн орж хуагай, үйлдвэрийн агуулах талбайг тандан судлах
- Гаднаас машин орж тавих, орхих гэх мэт асуудлууд үүсэх магадлалтай учир автомат хаалт хийлгэх шийдэлд хүрсэн. Гадна хаалгыг хаагаад түгжээд байх нь манай түрээслэгчдэд хүндрэлтэй, ихэнх түрээслэгчид маань орой ачаа бараагаа зөөх тээвэрлэх нь элбэг байдаг.

Хувьцаа эзэмшигч Ц.Банзрагч: Хөрөнгийн биржид тайлангуудаа өгсөн үү?

Нарийн бичгийн дарга: Монголын Хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд аудитаар болон төрний захиргааны байгууллагаар баталгалжсан санхүүгийн батлагдсан тайлангаа өгч, тэдгээр тайлангууд Хөрөнгийн биржийн сайтад цаг хугацаандаа тавигдсан.

Хувьцаа эзэмшигч Ч.Баясгалант: Аудитын дүгнэлт зэрэг, санхүүгийн үзүүлэлтүүд хангалттай гэж үзэж байна.

Хувьцаа эзэмшигч Ц.Банзрагч: Цахилгаан хангамжийн засварын ажлыг эхлүүлсэн нь сайн байна. Цахилгааны асуудлыг байнга нягталж, шалгаж ажиллах тал дээр нухацтай хандаарай.

Хурлын дарга: 2025 оны санхүүгийн жил манай компани ашигтай ажилласан хэдий ч ногдол ашиг хуваарилах хэмжээний ашигтай гэж үзээгүй учир ногдол ашиг тараахгүй гэсэн шийдвэрийг ТУЗ-ийн хурлаар шийдвэр гаргасан. Энэ жил манай компани ихээхэн засвар, төлөвлөлт хийх шаардлагатай байгаа. Гадна болон дотор засвар үйлчилгээг хийх төлөвлөгөөтэй байна. Учир нь түрээслэгчдээс ирэх санал гомдлын үндсэн дээрээ манай үйлдвэрийн барилга гадна талаасаа онго үзэмж маш муу байна. Мөн дотор дулаалгын асуудлыг шийдэхгүй бол өвөлдөө бол огт түрээслэгчгүй болж байна.

Хувьцаа эзэмшигч Ц.Баярмаа: Тайлангай танилцлаа. Асуух зүйл байхгүй ээ.

Хувьцаа эзэмшигчид: Санал байхгүй ээ.

Хурлын дарга: Өөр санал байхгүй бол Тооллогын комисс саналын хуудсаа өгөөд саналаа хураая. Хэлэлцэж байгаа асуудал болгоноор та бүхэн кумулятив аргаар саналын тоогоо саналын хуудсанд бичиж саналаа өгнө. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдэдээ сайн тайлбарлаад саналыг нь аваарай. *(Тооллогын комисс саналыг нэгтгэх хооронд 10 минут хурал тур шивсарлаад үргэлжлэв.)*

Хурлын дарга: Тооллогын комисс дүнгээ танилцуулаарай.

Хурлын дарга: Тооллогын комиссын дүнг үндэслэн, Тавилга ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолыг дараах байдлаар баталж байна:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт нийт 6 хувьцаа эзэмшигчдийн 77,040 (100%) саналын тоогоор дэмжигдэн батлагдлаа.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдэд Ц.Банзрагч, Ц.Баярмаа, Ц.Бат-Амгалан, Ч.Баясгалант, Ц.Байгальмаа, Ц.Баянмөнх нар сонгогдлоо. Хараат бус гишүүдэд Ч.Амгалантуяа, Д.Цэцэгмаа, Л.Батсуурь нар сонгогдлоо.
3. Ногдол ашиг хуваарилах, эсэх тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг танилцуулж батлагдлаа.

Хурлын дарга: Тус хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурлын дарга хурлыг хаая. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Нарийн бичгийн дарга: *Баяржаргал* Х.Баяржаргал

Хурлын дарга:



Ц.Байгальмаа